



**WWF Mongolia Programme Office**  
8<sup>th</sup> khoroo  
Sukhbaatar district  
Amar street-4  
Ulaanbaatar  
Mongolia  
Tel:+976 11 311 659  
Fax:+976 11 310 237  
E-mail:info@wwf.mn

## **Ажлын Удирдамж**

- Ажлын байр:** Нутгийн иргэдийн хөгжил, ядуурлыг бууруулах мэргэжилтэн
- Ажиллах газар:** Хэнтий аймаг, Дадал сум
- Ажиллах хугацаа:** Нийт 4 жил. Хөдөлмөрийн гэрээг жил бүр ажлын гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн сунгана.
- Удирдлага:** Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Ононгийн Сав газрын зохицуулагч
- Хамтран ажиллагсад:** Төслийн орон нутгийн баг, богино хугацааны зөвлөх баг, иргэд, байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, аймаг сумдын шийдвэр гаргагчид, Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа энэ төрлийн бусад төсөл, хөтөлбөрийн баг

### **Ажлын ерөнхий хүрээ:**

Онон голын сав газрын иргэдийн байгалийн нөөцийн менежментийн тусламжтайгаар өрхийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгох замаар жижиг бизнесийн санаачлагыг өрнүүлэх, бизнесийг амжилттай хэрэгжүүлэх чадавхийг бий болгох, орон нутгийн бүтээгдэхүүний зах зээлийн менежментийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа зөвлөлгөөгөөр хангана.

### **Голлох үүрэг хариуцлага:**

1. “Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх замаар ядуурлыг бууруулах” төсөл хэрэгжүүлж байгаа сумдад иргэдийн хамтын оролцоог идэвхжүүлэх арга замаар байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, Онон Балжийн БЦГ-ын орчны бүсийн зөвлөл, сав газрын зөвлөл байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.
2. Сав газрын зөвлөл, Онон Балжийн БЦГ-ын орчны бүсийн зөвлөл, байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн чадавхыг оролцооны аргаар үнэлж, хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
3. Сумдын зохицуулагч, орчны бүсийн зөвлөл, байгаль хамгаалагч нартай хамтран байгалийн нөөцийн менежментэд тулгуурласан өрхийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлийн жижиг, дунд бизнесийн санал, санаачлагыг оролцооны аргаар тодорхойлж, иргэдийн төсөл боловсруулах чадавхийг нэмэгдүүлнэ.
4. Сумдын зохицуулагч, орчны бүсийн зөвлөл, байгаль хамгаалагч нартай хамтран байгалийн нөөцийн менежментэд тулгуурласан үйлдвэрлэлийг бий болгох боломжийг судлах, зөвлөмж боловсруулна.
5. Сав газрын зөвлөл, орчны бүсийн зөвлөлийн эргэлтийн сангийн дотоод журам боловсруулах, гарын авлага гаргахад аргазүйн дэмжлэг үзүүлнэ.

6. Сав газрын зөвлөл, орчны бүсийн зөвлөлийн хүлээж авсан жижиг төслийг хэлэлцэж шалгаруулах, төслийн үр дүнг хэрэгжүүлэлтийн явцад хянах, үнэлгээ өгөх, амжилттай хэрэгжүүлэхэд чадавхийг дээшлүүлэх шаардлагатай сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.
7. Нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, сумдын зохицуулагчдын ажилтай байнга танилцан тэднийг ерөнхий удирдламж зөвлөгөөгөөр хангана.
8. Төслийн явцын, санхүүгийн тайлангуудыг тогтоосон хугацаанд боловсруулж, орон нутагт хэрэгжүүлж байгаа жижиг төслийн талаар газар зүйн мэдээллийн системтэй холбосон мэдээллийн санд төвлөрүүлнэ.
9. Төслийн үйл ажиллагааг бусад төсөл, хөтөлбөр, хандивлагчид, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай уялдуулна.
10. Олон нийттэй ажиллаж төслийн үйл ажиллагаа, хандивлагчдын талаарх мэдээллийг ард иргэдэд хүргэх ажлыг багийн бусад гишүүдтэй хамтран хийнэ.
11. Орон нутгийн зохицуулагчийн өгсөн бусад үүргийг гүйцэтгэнэ.

#### **Тавигдах шаардлага:**

##### Боловсрол

Нутгийн иргэдийн хөгжил, хөдөөгийн хөгжил болон бусад холбогдох салбар чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх. Нутгийн иргэдийн хөгжлийн талаарх ажлын туршлагыг дээд боловсролд тавигдах шаардлагатай дүйцүүлэн үзэх боломжтой.

##### Ажлын туршлага

Хөдөөгийн хөгжил, нутгийн иргэдийн хөгжлийн талаар дор хаяж 3 жил ажилласан байна.

##### Чадвар мэрэгшил

Нутгийн иргэд, орон нутгийн удирдагуудтай холбоо тогтоож хамтран ажиллах чадвартай байх

Олон нийттэй ажиллах, бусдад ажлаа ойлгуулах, багаар ажиллах чадвартай байна.

Төсөл боловсруулах, санхүүгийн төлөвлөлт, хяналт үнэлгээ хийх, мэдээллийн сантай ажиллах чадвартай байна.

#### **Сонирхсон хүмүүс өөрийн намтар, өргөдлөө 2008 оны 12 сарын 5-наас өмнө дараах хаягаар илгээх буюу авчирч өгнө үү?**

Дэлхийн байгаль хамгаалах сан  
(WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар  
Амарын гудамж-4  
Сүхбаатар дүүрэг  
8-р хороо  
Улаанбаатар,  
Утас:+976 11 311 659  
Факс:+976 11 310 237  
И-мэйл::info@wwf.mn